



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017 он 12 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар ХЭГ/1992

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан Таны асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын Сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

19900

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТООС ЕРӨНХИЙ САЙД  
У.ХҮРЭЛСҮХЭД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс 2017-2018 оны хүйтний улирлын цаг агаарын урьдчилсан төлөв, зудын эрсдэлийн зураглал болон сар тутмын урьдчилсан мэдээллийг боловсруулан гаргаж байгаа билээ. Энэ хүрээнд 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар боловсруулан гаргасан зудын эрсдэлийн зураглал болон сэрэмжлүүлэг мэдээллийг хавсаргав.

Монгол Улсын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн аж үйлдвэрийн яам эдгээр мэдээлэлд тулгуурлан өвөлжилт хүндэрч болзошгүй, бэлчээрийн даац хэтэрсэн бүс нутаг, аймгуудад өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлыг улам эрчимжүүлж, шаардлагатай бэлтгэл нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.

Өвөлжилт хүндрэхэд зөвхөн цаг уурын гэнэтийн үзэгдэлээс гадна сүүлийн жилүүдэд улам бүр хомсдож, доройтож байгаа бэлчээрийн даац, хүрэлцээ, олон давтамжтай гарч байгаа малын гоц халдварт болон паразиттах өвчний улмаас мал сүрэг тарга тэвээрэг бүрэн авч чадахгүй байх, хуурайшилт, гангийн улмаас отрын бэлчээрийн гарц тааруу гарсан зэрэг олон хүчин зүйл сөргөөр нөлөөлж байна.

Иймээс Засгийн газар ойрын хугацаанд 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэлийг эрчимжүүлэх арга хэмжээ авахын зэрэгцээ цаашид мал сүргийг эрүүлжүүлэх, бэлчээрийн даацыг зохистой түвшинд ашиглах, мал сүргийн бүтцийг зохистой болгох, бэлчээрийг нөхөн сэргээх, хамгаалах, цаг агаарын дунд, урт хугацааны таамаглал боловсруулах чадавхийг сайжруулах, хөдөө аж ахуйн салбарт зориулсан салбарын онцлогтой цаг агаарын урьдчилсан таамаглалыг илүү оновчтой боловсруулан гаргах зэрэг дунд хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын өргөн хүрээний арга хэмжээг авахаар төлөвлөн ажиллаж байна.

Саяхан Улсын Их Хурлаас Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Малын генетик нөөцийн тухай хуулийг батлан гаргасан нь мал аж ахуйн салбарын цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой үйл явдал болно гэж бид үзэж байна.

**АСУУЛТ 1. Отроор өвөлжиж, хаваржихад хэрхэн зохицуулалт хийж байгаа вэ. Бэлчээрийн даац жилээс жилд муудаж байгаад цаашид хэрхэн арга хэмжээ авах талаар.**

Энэ жил улсын хэмжээнд нийт 160.9 мянган малчин өрхөд 66.6 сая, хонин толгойд шилжүүлснээр 106.9 сая толгой малыг өвөлжүүлэх бэлтгэл ажлын зохион байгуулалт хийгдлээ.

Өвөл, хаврын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 25 хувь нь хүрэлцээтэй, 30 хувь нь 1-3 дахин хэтэрсэн, 10 хувь нь 3-5 дахин хэтэрсэн, 30 хувь нь олон дахин хэтэрсэн байна.

Иймд отор нүүдлийн хөдөлгөөн өмнөх жилээс 2.9 сая малаар илүү байх гэрээ хийгдлээ. Үүнээс, аймаг, сумдын Засаг даргын хооронд гэрээ байгуулан өөр аймгийн нутагт 3129 өрхийн 1.2 сая, өөрийн аймгийн бусад сумын нутагт 8194 өрхийн 3.9 сая, сум дундын отрын бүс нутагт 1259 өрхийн 402.0 мянга, аймаг дундын отрын бүс нутгийн захиргааны шийдвэрээр тусгай хэрэгцээний отрын бүс нутагт 1096 өрхийн 756.0 мянга, Хил хамгаалах ерөнхий газрын зөвшөөрлөөр хилийн зурвас газарт 3030 өрхийн 1.2 сая, Байгаль орчин, аялал жуулчлалын

яамны зөвшөөрлөөр улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 6092 өрхийн 2.3 сая мал, нийт 22.8 мянган өрхийн 9.8 сая толгой мал отроор өвөлжиж, хаваржихаар төлөвлөгдөж байна.

Отроор яваа малчдын малд гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, тарилга туулгалт, ариутгал халдваргүйжүүлэлтийг бүрэн хийж байна.

Цаашид бэлчээрийн даацад тохируулахын тулд малыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх, өөрөөр хэлбэл мал, махны экспортыг нэмэгдүүлэхэд чиглэх, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлэх, малын хөлийн татвар тооцох, Бэлчээр хамгаалах тухай хуулийг гаргах шаардлагатай байгаа болно.

**АСУУЛТ 2. Малчдын эрүүл мэндийн асуудалд хэрхэн анхаарч ажиллах вэ. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эмийн нөөц, шатахуун гэх мэт шаардлагатай зүйлсийг бэлтгэж, төсвийг шийдвэрлэсэн эсэх талаар.**

*Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:*

Аймгуудын эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн судалгаагаар 19058 жирэмсэн эмэгтэй, 5 хүртэлх насны 164365 хүүхэд, 91731 өндөр настан, 58405 хөгжлийн бэрхшээлтэй иргэн өвөлжилт хүндэрсэн болон отор нүүдлийн байдалтай алслагдсан орон нутагт амьдарч байна. Иймд дээрх иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй хүргэх зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгээд байна:

- а) Орон нутгийн сумын эрүүл мэндийн төвүүдэд эх, хүүхдэд үзүүлэх тусламжийн тасралтгүй бэлэн байдлыг хангах, жирэмсэн эмэгтэйчүүдийг онцгой анхаарч хяналтыг сайжруулах зорилгоор:
  - жирэмсэн эмэгтэйг орон нутгийн засаг, захиргааны харьяалал харгалзахгүйгээр отор нүүдэл хийж байгаа суманд нь хяналтад авч, тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх;
  - жирэмсэн эмэгтэйг эхийн амрах байранд урьдчилан авчрах;
  - дутуу төрөх эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдийг онцгой анхаарч, хувь хүн, гэр бүлд эрсдэлийг ойлгуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах газарт ойр байрлах;
  - эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдийг дараагийн шатлалд хугацаа алдалгүй шилжүүлэх талаар сэрэмжлүүлэг хүргүүлж, хяналт тавих, зохион байгуулалтын арга хэмжээ авах;
  - эх барих, хүүхдийн тусламж үйлчилгээний тулгамдсан асуудлаар шуурхай цахим хурлыг аймаг бүрээр зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх зэргээр ажиллаж байна.
- б) Бага насны хүүхэд, хөхүүл эхчүүдийн дархлааг дэмжих, өвчлөлөөс сэргийлэх зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн Гамшгийн хөтөлбөрийн хүрээнд бага насны хүүхэд, хөхүүл эхчүүдийн дархлааг дэмжих, өвчлөлөөс сэргийлэх зориулалтаар А аминдэм, олон найрлагат бичил тэжээлийн болон бусад бэлдмэлийг хуваариллаа. Үүнд:
  - Эрүүл мэндийн сайдын А/105 дугаар тушаалаар бага насны хүүхэд болон хөхүүл эхчүүдэд өндөр тунт А аминдэм, өвөлжилт хүндэрч болзошгүй 16 аймгийн 112 сумдад бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхчүүдэд олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл;

- Эрүүл мэндийн сайдын А/281 дугаар тушаалаар бага насны хүүхдийн эмчилгээнд хэрэглэх шингэн сэлбэх давсны уусмал болон цайрын бэлдмэлийг бүх аймгуудад, 15 аймгийн 96 суманд хүүхдэд зориулсан олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл;
  - Эрүүл мэндийн сайдын А/374 дугаар тушаалаар бага насны хүүхэд болон хөхүүл эхчүүдэд өндөр тунт А аминдэм, 14 аймгийн 95 суманд жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхчүүдийн аминдэм, эрдэс тэжээлийг тус тус хуваарилав.
- в) Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тогтмол 2 сарын эмийн нөөцтэй байлгахад анхаарч, эрүүл мэндийн байгууллагад хяналт хийв. Тус хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар тушаалын дагуу 50 нэрийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад 80 гаруй хувьтай байна.
- г) Эрүүл мэндийн яамнаас өвөлжилт хүндрэх төлөвтэй аймгуудаас эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдийн судалгааг 14 хоног тутамд шинэчлэн авч, Онцгой байдлын ерөнхий газар болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллаж байна.
- д) Томуу, томуу төст өвчин ихээр дэгддэг өвлийн улирлыг эдийн засгийн болон эрүүл мэндийн хохирол багатай даван туулах, дэгдэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор:
- Дархлаажуулалтын тухай хуульд тусгагдсан заавал хийх дархлаажуулалтын товлолын дагуу 0-2 насны хүүхдийг халдварт 11 өвчний эсрэг 6 төрлийн вакцинд хамруулж байна. 2017 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд нийт хамрагдвал зохих хүүхдийн 98-аас дээш хувийг товлолын дагуу вакцинд хамруулаад байна. Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудад 0-2 насны хүүхэд товлолт вакцинжуулалтад хамрагдаагүй тохиолдолд нөхөн дархлаажуулалтад хамруулна;
  - Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдийн ууж хэрэглэх эмийн үнэд хөнгөлөлт үзүүлэх тухай” 2017 оны 1 дүгээр тогтоолын дагуу 10 нэрийн ерөнхий нэршлийн эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувийн хөнгөлөлттэй үнээр 124 мянган хүүхдэд 1 тэрбум төгрөгийн эмийг олгосон. 2018 онд томуу, томуу төст өвчний үед 5 хүртэлх насны хүүхдэд хэрэглэх 6 нэрийн 16 тун, хэлбэрийн эмийг хөнгөлөлттэй үнээр олгох саналыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлээд байна.

*Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах чиглэлээр:*

Энэ оны хувьд өвөлжилт хүндэрсэн аймаг, орон нутагт хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээг зөв зохион байгуулах, тусламж үйлчилгээний хүртээмжийг хэвийн түвшинд байлгах үйл ажиллагааг 3 үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөж байна.

Эхний шатанд, нэмэлт хүний нөөц шаардлагагүйгээр одоо ажиллаж байгаа хүний нөөцөд тулгуурлан ажиллах буюу тухайн орон нутгийн нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, уртасгасан цагаар болон амралтын өдрүүдэд ээлжээр ажиллуулах горимд шилжүүлнэ.

Өвөлжилт хүндэрсэн орон нутагт нэн тэргүүнд хүн амд сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал эмчилгээ шаардлагатай болдог бөгөөд энэ зорилгоор Сэтгэцийн

эрүүл мэндийн үндэсний төвд 6 баг (баг тус бүрт сэтгэл зүйч-1, сэтгэцийн эмч-3)-ийг ажиллуулахаар бэлтгээд байна.

Хоёрдугаар шатанд буюу нэмэлт хүний нөөц шаардлагатай тохиолдолд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн болон үндсэн мэргэшлийн сургалтанд хамрагдаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдээс орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад нэмэлтээр ажиллуулна. Энэ хүрээнд:

- Тухайн орон нутгаас ирж суралцаж байгаа эмч нарыг сургалтаас чөлөөлж орон нутагт нь ажиллуулах;
- Шаардлагатай тохиолдолд нийслэлээс болон өвөлжилт хүндрээгүй байгаа аймаг, орон нутгаас суралцаж байгаа эмч нарыг сургалтаас чөлөөлж, орон нутагт ажиллуулахаар тус тус зохион байгуулна.

Төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог харуулбал:

№	II ээлжинд дайчлагдах эмнэлгийн мэргэжилтэн	Эрүүл мэндийн хөгжлийн төвд бүртгэлтэй	АШУУИС-д бүртгэлтэй	Нийт
1.	Үндсэн мэргэшлийн 2-3 дугаар дамжаанд суралцаж байгаа их эмч	509 (үүнээс 289 нь орон нутгаас)	333	842 (үүнээс 289 нь орон нутгаас)
2.	Үндсэн мэргэшлийн 1 дүгээр дамжаанд суралцаж байгаа их эмч	460* (үүнээс 241 нь орон нутгаас)	300	760 (үүнээс 241 нь орон нутгаас)
<b>РЕЗИДЕНТ БҮГД</b>				1602 (үүнээс 530 нь орон нутгаас)
3.	Төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцаж байгаа их эмч	128 (үүнээс 76 нь орон нутгаас)	98	226 (үүнээс 76 нь орон нутгаас)
4.	Төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцаж байгаа сувилагч	263 (үүнээс 179 нь орон нутгаас)	110	373 (үүнээс 179 нь орон нутгаас)
<b>ТӨГСӨЛТИЙН ДАРААХЬ СУРГАЛТАНД ХАМРАГДАЖ БАЙГАА БҮГД</b>				2201 (үүнээс 785 нь орон нутгаас)

\*Энэ жилийн резидентийн элсэлтийн бүртгэл дуусаагүй тул 10 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар бүртгэгдээд байгаа эмчийн тоогоор авав.

Гуравдугаар шатанд буюу нийт нутгаар өвөлжилт хүндэрч, хоёрдугаар шатанд дайчилсан хүний нөөц хүрэлцэхгүй тохиолдолд нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа эмнэлгүүдээс нэмэлтээр хүний нөөц дайчилна. Энэ хүрээнд:

- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагаас шаардлагатай мэргэжлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг орон нутагт богино хугацаагаар ээлжээр ажиллуулах;
- Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага, анагаах ухааны боловсрол олгох сургуулиудын багш, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудаас шаардлагатай мэргэжлээр нэмэлт хүч дайчлах;
- Шаардлагатай нөхцөл байдал үүсвэл эрүүл мэндийн салбарт одоогоор ажиллаагүй байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийг сайн дурын үндсэн дээр дайчилна.

Эрүүл мэндийн сайдын багц дахь төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээнд 2017 оны 10 дугаар сарын байдлаар дүн шинжилгээ хийж, өр гаргахгүй ажиллах, авлага барагдуулах, байгууллагын тусламж, үйлчилгээг хэвийн явуулахад анхаарч ажиллах чиглэлээр үүрэг даалгавар өгч байна.

Төсөвт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, үүссэн өр төлбөрийг барагдуулах, 2017-2018 оны өвлийг хүндрэлгүй давах зорилгоор эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай болон алсын дуудлагаар ажиллах тээвэр,

шатахуун, томилолт, эм эмнэлгийн хэрэгслийн зардлын нөөцийг нэмж тооцон 3.6 тэрбум төгрөгийг 2017 оны төсвийн тодотголд тусган шийдвэрлүүлээ. Үүнд:

- 2017 оны эхний 8 сарын байдлаар аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын үүссэн өр төлбөрийг барагдуулах зорилгоор нийт 2.8 тэрбум төгрөгийн төсвийг тодотгуулах саналыг хүргүүлснээс 2.3 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн,
- Орон нутгийн бусад эрүүл мэндийн байгууллагуудын өр төлбөрийг барагдуулах, өвөлжилтийн бэлэн байдлыг хангахтай холбоотойгоор 0.7 тэрбум төгрөгийн санал хүргүүлж, 0.5 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлсэн,
- Сумын эрүүл мэндийн төвүүдийн өвөлжилтийн бэлэн байдлыг хангах зорилгоор төвлөрсөн халаалтад холбогдсон сумдын тогтмол зардал, дутагдаж байгаа түлш, халаалтын зардал, эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 0.4 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэн төсөвт тусгуулсан,
- Аймгуудын сумын эрүүл мэндийн төвд үүссэн цалингийн өр 113.5 сая, халаалтын өр 232.7 сая, эмийн өр 74.8 сая төгрөгийг барагдуулах асуудлыг шийдвэрлэлээ.

Цаашид нөөцийг нэмэгдүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, сумын эрүүл мэндийн төвүүдийн өвөлжилтийн бэлэн байдлыг хангах зорилгоор орон нутгийн хэмжээнд төсвийн зохицуулалт хийж, хэмнэлттэй байгаа бусад зардлыг тээвэр, шатахуун, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд зарцуулахаар чиглэл өгч ажиллаж байна.

**АСУУЛТ 3. Малчдын түвшинд өвс, тэжээлийн бэлтгэл 70.1 хувьтай байгаад дүгнэлт хийж хэрхэн шийдвэрлэн ажиллах вэ.**

Энэ жилийн хадлан бэлтгэх ажилд 7141 дугуйт трактор, 5735 бага оврын тракторууд дагалдах хэрэгслийн хамт, 621 хаман боогч, 1000 морин хадуур, 5000 гар болон хөдөлгөөнт хадуур, тармуур ажиллалаа.

Хадлангийн техникийн шинэчлэлд зориулж ОХУ-аас техникийн зээлийн хүрээнд хаман боогч 40 ширхэг, бага оврын трактор, хадуур тармуур тус бүр 20 ширхэг орж ирснийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 30 хувийн урьдчилгаатай, 5 жилийн хугацаатай лизингээр олголоо.

Малчдын түвшинд ургацын урьдчилсан балансаар 850.0 мянган тонн хадлан авахаар тооцоологдож байсан боловч 935.7 мянган тонн хадлан бэлтгэсэн нь байгалийн нөөцийг хангалттай ашигласан гэж үзэж байна. Харин хүчит болон шүүст, гар тэжээл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, шаардагдах тэжээлийн 70.2 хувийг бэлтгэсэн.

Малчдын өвс, тэжээлийг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн тодотголд 40.0 тэрбум төгрөг тусган аймгуудад борлуулалт хийх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж, хүүгүй санхүүгийн эх үүсвэрийг олгох бодлогын болон зээлийн гэрээнүүд хийгдсэн.

Энэхүү үйл ажиллагаа нь 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлэх бөгөөд малчдад мал, махаар солилцох, ноосны урамшууллаар суутган тэжээл худалдан авах нөхцөлийг нээлттэй болголоо.

Засгийн газрын 2017 оны 186 дугаар тогтоолоор баталсан аймгийн аюулгүйн нөөц 88.5 хувь, сумдын аюулгүйн нөөц 58.5 хувийн биелэлттэй байсан. Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлэхэд зориулж төсвийн тодотголоор 4.5 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт тусган, нөхөн бүрдүүлэлтийг

дотоодоос худалдан авах чиглэл өгсний дагуу бүх аймгууд нөөцөө бүрэн бүрдүүллээ.

**АСУУЛТ 4. Өвөлжилт хүндэрч, хөдөө орон нутаг руу өвс тэжээл болон бусад тусламж хүргэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд онцгой байдлын алба, албан хаагчид бэлэн эсэх, тэдний хувцас хэрэглэл, техник, тоног төхөөрөмжийн хангалт хэр байгаа талаар.**

Байгалийн гамшиг, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай давах зорилгоор Засгийн газрын 2001 оны 47 дугаар тогтоолоор 1 хонин толгойд 1 кг өвсөөр тооцон нийт малын 25 хувийг 3-аас даашгүй хоног тэжээх өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхээр заасан.

2017 оны эхний хагас жилийн байдлаар төв, орон нутаг дахь улсын нөөцийн анги, салбар, цэгүүдэд 3756 тонн өвс, 3924 тонн малын тэжээлийн үлдэгдэлтэй байсан бөгөөд 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд батлагдсан төсвийн хөрөнгөөр нийт 8350 тонн өвс, 4700 тонн тэжээлийг 100 хувь бүрдүүлсэн.

2017 оны төсвийн тодотголоор нэмж 5280 тонн өвс, 3410 тонн малын тэжээл, 500 тонн нэмэлт тэжээлийг тус тус бүрдүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор өвс, тэжээлийг бүрдүүлж дуусгахаар ажиллаж байна.

Улсын нөөцөд 2017 оны жилийн эцэст нийт 17464 тонн өвс, 12034 тонн малын тэжээлийн бүрдүүлэлттэй байхаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд энэ нь улсын хэмжээнд нийт малын 25 хувийг 2 хоног тэжээх нөөц юм.

Засгийн газрын 186 дугаар тогтоолоор аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 32.0 мянган тонн өвс, 13.1 мянган тонн тэжээл бэлтгэх үүрэг даалгавар өгснөөс 23.0 мянган тонн өвс, 5.3 мянган тонн тэжээл бэлтгэсэн нь аймгийн түвшинд 88.5 хувь, сумын түвшинд 58.5 хувийн бүрдүүлэлттэй байгаа юм.

Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорнод, Говь-Алтай, Өвөрхангай, Завхан, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 15 аймгийн 95 суманд 159 даваа, гүвээ, 30 гаруй тал хөндий газар байнгын цасанд хаагдаж иргэдэд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээ болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хүндрэл бэрхшээл үүсдэг тул улсын болон орон нутгийн чанартай авто зам, даваанд "Шуурхай хэсэг"-ийн 47 нэгжид нийт 198 хүн, 160 техник хэрэгслийг 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл ажиллуулна.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага өвлийн улиралд 2648 алба хаагч, аврах ажлын 29 нэгж, тусгай зориулалтын 81 нэгж, ачаа, хүн тээврийн 126 нэгж, туулц сайтай 38 нэгж автомашин, сансрын холбооны иридиум 27 гар утас, 548 хэт богино долгионы гар радио станц, 99 байршил тогтоогчтой үүрэг гүйцэтгэнэ.

**АСУУЛТ 5. Малчдыг орлоготой болгох, мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар ямар бодлого хэрэгжүүлэн ажиллаж байгаа болон цаашид хэрхэн ажиллах талаар.**

2017 оны 11 дүгээр сарын байдлаар ОХУ-д 520.0 тонн үхрийн мах, БНХАУ, ОХУ, Казахстан, Япон улсад нийт 20.8 мянган тонн адууны мах, Иран, Катар улсад

2.0 мянган тонн хонь, ямааны мах, нийт 23.3 мянган тонн мах экспортлон 120.0 тэрбум төгрөгийн орлого олсон.

Дулааны аргаар боловсруулсан мах махан бүтээгдэхүүний хувьд 1880 кг-ийг экспортлоод байна. Энэ нь өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад махны экспорт 5.6 дахин илүү байгаа бөгөөд малчдын орлого төдий хэмжээгээр нэмэгдсэн гэж үзэж байна.

Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн хуралдаанаар 2017-2018 оны мах экспортлох квотыг тогтоосон бөгөөд 28.9 мянган тонн үхрийн мах, 43.6 мянган тонн адууны мах, харин хонь, ямааны маханд хязгаар тогтоохгүйгээр экспортлохоор боллоо.

**АСУУЛТ 6. Хальтиргаа гулгаа үүсч, замын хөдөлгөөнийг хаадаг орон нутгийн зам, давааны арчилгаанд Авто замын засвар, арчилгааны компаниуд бэлэн үү. “Хар цэгүүд”-д өвлийн пост гаргах асуудалд хэрхэн анхаарч байгаа вэ.**

Авто замын тухай хуулийн 17.3-д зааснаар нийслэл, орон нутгийн чанартай авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, түүнээс эрх олгосон этгээд байна гэж заасан.

Харин олон улс, улсын чанартай авто зам, зам байгууламжийн засвар арчлалтын ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг Зам, тээврийн хөгжлийн төв гүйцэтгэдэг. Энэ хүрээнд 20 төрийн өмчит хувьцаат компани, 8 хувийн хэвшлийн компани, нийт 28 зам хариуцагч компанийн Авто замын сангийн хөрөнгөөр 2017 онд гүйцэтгэх авто зам, гүүрийн арчлалт, урсгал засварын ажилд зөвлөх үйлчилгээг захиалагчийн хяналтын зардлаар гүйцэтгэж байна.

Олон улс, улсын чанартай авто замын хаагдаж боогддог хэсгүүдэд 26 авто замын засвар арчлалтын компанийн 37 чиглэлийн замд 48 шуурхай ажлын хэсэг ажиллаж байна. 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс уулархаг бүсийн 9 авто замын засвар арчлалтын компанийн 16 чиглэлийн авто замд 22 инженер техникийн ажилтан, 58 замчин, 45 механизмчин, 77 машин механизм бүхий нийт 103 хүний бүрэлдэхүүнтэй 22 шуурхай ажлын хэсэг гарч ажиллаж байна.

Хальтиргаа гулгаа үүсдэг хэсгүүдэд 120 ширхэг тэмдгийг байршуулсан ба 108 байршилд 5926.8 м.куб элс, хайрган овоолго хийж, бэлэн байдалд 1317 м.куб элс, хайрган хольц, 171.8 м.куб давсны нөөц бэлтгэн, хөвөөн дээрх овоолгыг тухай бүр сэргээж, давс, цас хайлуулах бодис тодорхой хэмжээгээр нөөцлөн ажиллаж байна.

Улсын чанартай авто замын дагуу осол аваар гардаг 25 зам хариуцагч компанийн 165 цэг байдаг. Үүнээс, хөдөлгөөний эрчим их, хотод ойр 6 цэгт “Хөдөлгөөнт эргүүл” ажиллуулахаар төлөвлөж байна.



## ЗУДЫН ЭРСДЭЛИЙН МЭДЭЭ

2017 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар

Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн зудын эрсдэлийн зургийг боловсруулахдаа өнгөрсөн зуны ган зуншлага, бэлчээрийн даац, бэлчээрийн ургац, малын тоо, агаарын температур, хур тунадасны хазайц, энэ жилийн цасны бүрхэц, зузаан, нягт болон дараа сарын агаарын температур, хур тунадасны урьдчилсан мэдээ зэрэг 10 гаруй мэдээллийг ашиглаж байна.

2017 оны зун ихэнх нутгаар гантай болон гандуу байсан нь ургацын хэмжээ бага байх, мал тарга хүч дутуу авах, өвөл-хаврын бэлчээрийн даац ихээхэн хэмжээгээр хэтрэх, бэлчээрийн нөөц хүрэлцээ муу, улмаар мал өвөлжилт, хаваржилт хүндрэх нөхцөл бүрдэхэд хүргээд байна.

2017 оны 7 дугаар сарын 31-ний байдлаар нийт нутгийн 70 орчим хувьд гандуу, 10 гаруй хувьд гантай байлаа.

11 дүгээр сарын 30-ны байдлаар нутгийн 50 гаруй хувьд цастай, Увс, Завхан, Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр, Дархан-Уул, Хэнтий, Сүхбаатар, Дорнодын ихэнх, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Дундговь, Дорноговийн зарим сумдын нутгаар 0-10 см зузаан, нягт нь 0.10-0.28 г/см<sup>3</sup>, Баян-Өлгийн Даян/Сагсай/, Увсын Малчин, Баруунтуруун, Хяргас, Завханы Баянтэс, Цэцэн-Уул, Тосонцэнгэл, Баянхайрхан, Түдэвтэй, Тэс, Эрдэнэхайрхан, Архангайн Хашаат, Өвөрхангайн Есөнзүйл, Булганы Сэлэнгэ, Сэлэнгийн Орхонтуул, Төвийн Баян, Бүрэн, Цээл, Дэлгэрхаан, Улаанбаатарын Налайх/Тэрэлж/, Хэнтийн Дархан, Өндөрхаан, Мөрөн, Сүхбаатарын Асгат, Мөнххаан сумдад 11-20 см, нягт нь 0.10-0.31 г/см<sup>3</sup>, Завханы Сонгино, Өвөрхангайн Бүрд, Булганы Могод, Гурванбулаг, Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн, Орхон, Хангал, Хишиг-Өндөр, Баяннуур, Рашаант, Орхоны Баян-Өндөр, Жаргалант, Төвийн Лүн, Баян-Өнжүүлд 21-45 см зузаан, 0.12-0.36 г/см<sup>3</sup> нягт цастай байна.

2017 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар гаргасан зудын эрсдэлийн зургаас үзвэл *нийт нутгийн 40 гаруй хувьд их (18% нэн их, 24% их), 20 гаруй хувьд (23%) нь дунд зэрэг эрсдэлтэй* гарлаа.

Үүнээс Увсын зүүн тал, Завханы баруун хагас, Баянхонгорын зүүн хойд хэсэг, Архангай, Өвөрхангайн залгаа нутаг, Булганы өмнөд хагас, Орхон аймаг бүхэлдээ, Төв аймгийн баруун хагас болон зүүн өмнөд хэсэг, Хэнтийн өмнөд, Дорноговийн хойд, Сүхбаатарын баруун болон зүүн хэсгээр хамгийн их эрсдэлтэй гарлаа.

Мөн Ховд, Говь-Алтайн хойд, Архангайн баруун хойд, Баянхонгор, Сүхбаатарын төв хэсэг, Өмнөговь, Дорнодын зарим сумдын нутгаар их эрсдэлтэй байна.

Зудын нөхцөл байдал үүсээд байгаа дээрх аймаг, сумдыг эхний ээлжинд анхаарах, цаашид авах арга хэмжээг оновчтой, шуурхай зохион байгуулах, олон улсын болон хүмүүнлэгийн тусламж, дэмжлэгийг татан оруулах зэрэг арга хэмжээг эртнээс авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн

84°00'E

88°00'E

92°00'E

96°00'E

100°00'E

104°00'E

108°00'E

112°00'E

116°00'E

124°E

# ЗУДЫН ЭРСДЭЛИЙН ЗУРАГ 2017 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ БАЙДЛААР







Сүхбаатар

Говь-Алтай

Орхон

Дорнод






## Таних тэмдэг

-  Аймгийн хил
-  Сумын хил
-  Аймгийн төв
-  Нуур



Боловруулсан: Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэн  
Огноо: 2017 оны 12 дугаар сарын 04

## Эрсдэлийн зэрэг

-  Хамгийн бага
-  Бага
-  Дунд
-  Их
-  Нэн их

92°00'E

96°00'E

100°00'E

104°00'E

108°00'E

112°00'E

116°00'E

124°E